



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 15 (152)

Монгол Улсын Хууль:

- *Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай*
- *Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай*
- *Хэлэлцээр соёрхон батлах тухай*

Монгол Улсын Их Хурлын тогтоол:

- *Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай*
- *Сонгуулийн зардлын хэтжээг батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны дөрөвдүгээр сарын 21 № 15(152)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | |
|--|-----|
| 167. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай
(2000-4-6-ны хууль) | 323 |
| 168. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай
(2000-4-6-ны хууль) | 324 |
| 169. Хэлэлцээр соёрхон батлах тухай
(2000-4-14-ний хууль) | 324 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|---|-----------|-----|
| 170. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг
буцаах тухай | Дугаар 24 | 324 |
| 171. Монгол Улсын Их Хурлын ээлжиг сонгууль
товлон зарлах тухай | Дугаар 25 | 325 |
| 172. Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай | Дугаар 26 | 325 |
| 173. Газар ашиглуулах тухай | Дугаар 27 | 325 |
| 174. Засгийн газарт эрх олгох тухай | Дугаар 28 | 326 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- | | | |
|--|-----------|-----|
| 175. Татан буугдсан “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ”
сонины өмчийг хувьчлах тухай Монгол Улсын
хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай | Дугаар 85 | 326 |
|--|-----------|-----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 4 дүгээр
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу “Монгол нүүрс” төсөл, мөн Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу “МОН-П4”, “МОН-П5” төслүүдийн хүрээнд Багануур, Шивээ-

Овоогийн уурхайнуудын шинэтгэл, өргөтгөлд зориулан импортоор нийлүүлсэн, нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, материалыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗАРТ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Гаалийн тарифын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

алслагдсан бүс нутагт импортоор авах гурилын гаалийн татварын хувь хэмжээг өөрчлөн зохицуулах эрхийг Засгийн газарт олгосугай.

1. Таваарын улаан буудай, малын тэжээл, 2000 оны хаврын тариалалтад зориулж импортлох таримлын үр, бордоо, ургамал хамгааллын бодис болон төвөөс

2. Энэ тогтоолыг 2000 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 3 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

ТАТАН БУУГДСАН “АРДЫН ЭРХ”, “ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ” СОНИНЫ ӨМЧИЙГ ХУВЬЧЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Татан буугдсан “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонины өмчийг хувьчлах тухай Монгол Улсын хуулийн зарим заалтыг зөв ойлгон хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дүгээр заалт, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

гэдэгт эдгээр сонинг үүсгэн байгуулсан үеэс, татан буугдах хүртэлх хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр буюу томилолтоор ажиллаж, уг сонины газраас цалинжиж байсан ажилчин, ажилтан нарыг хамааруулан ойлгоно.

Татан буугдсан “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонины өмчийг хувьчлах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн зарим заалтыг дор дурьдсанаар тайлбарласугай:

2. Хуулийн мөн зүйл заалтын “сонин хэвлэл эрхлэн гаргадаг хуулийн этгээд, иргэд” гэдэгт Хууль зүйн яам болон бусад эрх бүхий байгууллагад бүртгүүлэн, зөвшөөрөл авсан сонин хэвлэлийг тодорхой хугацаандаа тогтмол гаргаж байгаа хуулийн этгээд, иргэн болон тэдгээртэй хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр орон тооны ажил, албан тушаал эрхэлж байгаа сурвалжлагч, сэтгүүлчдийг хамааруулна.

1. Татан буугдсан “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонины өмчийг хувьчлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонинд ажиллаж байсан ажиллагсад”

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ ШҮҮГЧ

Ч.ГАНБАТ А.ДОРЖГОТОВ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэл үйлдвэрт хэвлэв.

☎ 329487